# МОНГОЛ УЛС
# ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
# ЗАСАГ ДАРГЫН
# ЗАХИРАМЖ

2025 оны 06 сарын 27 өдөр          Дугаар А/382          Есөнбулаг сум

## Гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.1 дэх заалт, 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэг, 30.2.1 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн "Аймгийн 2025 оны төсөвт өөрчлөлт оруулан батлах тухай" 23 дугаар тогтоол, Үнэлгээний хорооны 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 624 дугаар зөвлөмжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар санхүүжигдэх ГААХААГ/20250101019 дугаартай "Говь-Алтай аймгийн төв Алтай хотын Лодойдамбын гудамжны тохижилт, шинэчлэлт"-ийн ажлыг "Гуулин зам" ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлэх эрхийг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ж.Мянганбаяр)-т олгосугай.

2.Гүйцэтгэгчийн санал болгосон ажил гүйцэтгэх хугацаа, ажлын тоо хэмжээ, техникийн тодорхойлолт зэргийг үндэслэн холбогдох хууль, журмын дагуу эрх үүрэг захиалагчийн хяналт, хариуцлагыг гэрээнд тодорхой тусгаж, хэрэгжилтийг тайлагнаж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ж.Мянганбаяр)-т үүрэг болгосугай.

3.Ажлын гүйцэтгэл, чанар, санхүүжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Д.Чинзориг), Санхүү, төрийн сангийн хэлтэс (Л.Хаш-Эрдэнэ), Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Д.Бүянхишиг)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА          Г.ЧИНБАТ

D:Ajil, zahiramj Zax ZD 2025

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ

᠒᠐᠑᠒ ᠐᠕ ᠒᠒

8200010628